



CFLI/FCIL

Орон нутгийн санаачилгыг
дэмжих Канад сан



ЦОГЦ ХӨГЖЛИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



ХУУЛЬ ТОГТООХ ТҮВШИНД ОРОН НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Гарын авлага



UIN.MN
СУДАЛГААНЫ САН





Хянасан:

М.Энхбадрал Цогц Хөгжлийн Үндэсний Төвийн Гүйцэтгэх захирал

Боловсруулсан:

Г.Доржтүвдэн Цогц Хөгжлийн Үндэсний Төвийн ахлах судлаач

Ж.Батболд Цогц Хөгжлийн Үндэсний Төвийн судлаач

Г.Төгөлдөр Цогц Хөгжлийн Үндэсний Төвийн хөтөлбөрийн ажилтан

А.Номин-Эрдэнэ Цогц Хөгжлийн Үндэсний Төвийн хөтөлбөрийн ажилтан

Тайлбар

Энэхүү гарын авлагыг Орон нутгийн санаачилгыг дэмжих Канад сан (Canada Fund for Local Initiatives)-гийн санхүүжилтээр Цогц Хөгжлийн Үндэсний Төв ТББ бүтээв.

Уг хэвлэлийн агуулгыг Цогц Хөгжлийн Үндэсний Төв ТББ хариуцах бөгөөд аливаа тохиолдолд санхүүжүүлэгч байгууллагын байр суурийг илэрхийлээгүй болно.

Disclaimer

This publication was funded by the Canada Fund for Local Initiatives (CFLI). The content of this material is the sole responsibility of National Center for Comprehensive Development NGO and does not necessarily reflect the views of CFLI or the Government of Canada.

ЭНЭХҮҮ ГАРЫН АВЛАГА НЬ...

Цогц Хөгжлийн Үндэсний Төвийн Засаглалын хөтөлбөрийн хүрээнд Орон нутгийн санаачилгыг дэмжих Канад сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Монгол Улсын хөдөө орон нутгийн иргэд, залуучуудын ардчилсан оролцоо болон парламентын ил тод байдлыг иргэний боловсрол, дижитал платформ, олон нийтийн оролцоогоор бэхжүүлэх нь” төслийн хүрээнд энэхүү гарын авлагыг бүтээлээ. Энэхүү гарын авлага нь орон нутгийн иргэдийг хууль тогтоох үйл ажиллагаанд идэвхтэй, мэдээлэлтэй, зохион байгуулалттай оролцох нөхцөлийг бүрдүүлэх замаар ардчилсан засаглал, төлөөллийн тогтолцоог бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой.

Орон нутгийн иргэдийн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох боломж, чадавхыг нэмэгдүүлэх, хууль тогтоох үйл явцын үндсэн үе шат, парламентын шийдвэр гаргалтын механизм, иргэдийн оролцоо бодит нөлөө үзүүлэх боломж зэрэг мэдээллийг гарын авлагаас ойлгомжтой, системтэй байдлаар авах боломжтой.

Иргэд өөрсдийн санал бодол, тулгамдсан асуудлыг хууль тогтоох түвшинд үр дүнтэй хүргэхэд, иргэдийн оролцоог зөвхөн мэдэгдэх төдий хүрээнд бус бодлогын түвшинд нөлөөлөхүйц хэмжээнд хүргэх нь чухал юм. Тиймээс гарын авлага нь парламентын ил тод байдал, хариуцлагыг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцооны ач холбогдлыг тодотгож, орон нутгийн бодит хэрэгцээ, ашиг сонирхол хууль, шийдвэрт тусгагдах боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Энэхүү гарын авлага нь аймаг, сум, дүүргийн түвшинд амьдарч буй, орон нутгийнхаа асуудлыг шийдвэр гаргалтын түвшинд хүргэх сонирхол, идэвх оролцоотой иргэдэд зориулагдсан. Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй иргэний нийгмийн байгууллага, иргэдийн санаачилгын бүлэг, орон нутгийн бодлогын хэлэлцүүлэгт оролцож буй оролцогч талуудыг хамарна.

Түүнчлэн залуучууд, эмэгтэйчүүд, малчид зэрэг орон нутгийн төлөөлөл бүхий бүлгүүд, орон нутгийн төлөөллийн байгууллагатай харилцаж, иргэдийн дуу хоолойг дамжуулан ажилладаг иргэд, идэвхтнүүдэд зориулсан практик баримт бичиг юм. Гарын авлага нь эдгээр зорилтот бүлгийн хувьд хууль тогтоох түвшинд оролцох ойлголт, арга замыг нэгтгэн өгч, тэдний оролцооны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэнэ.



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Хууль тогтоох үйл явцын тухай

АГУУЛГА

- Хэн хууль санаачилдаг вэ?
- УИХ-ын бүтэц, зохион байгуулалт
- Хуулийн төслийг боловсруулах үе шат
- Хуулийн төслийг хэлэлцэн батлах үе шат
- Иргэд хэрхэн оролцох боломжтой вэ?

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Хууль тогтоох үйл явцын тухай

Иргэдийн амьдралд нөлөөлж байгаа олон асуудал хууль, Улсын Их Хурлын шийдвэрээр зохицуулагддаг. Жишээлбэл, орон нутгийн хөгжлийн бодлого, төсвийн хуваарилалт, байгаль орчны хамгаалалт, нийгмийн үйлчилгээ, мал аж ахуй, газрын ашиглалт зэрэг асуудал хууль тогтоомжийн хүрээнд шийдэгддэг.

Хууль тогтоох үйл явц нь хууль санаачлахаас эхлэн боловсруулах, түүнийг хэлэлцэх, батлах, хэрэгжүүлэх хүртэлх дараалсан шатуудаас бүрддэг. Энэ үйл явцад Улсын Их Хурал, Байнгын хороо, ажлын хэсгүүд оролцож, хуулийн төслийг судалж, санал солилцож, эцсийн шийдвэрийг гаргадаг.

Монгол Улсын иргэн бүр хууль тогтоох үйл явцын талаар мэдээлэл авах, санал бодлоо илэрхийлэх, төлөөлөгчдөөрөө дамжуулан шийдвэр гаргахад нөлөөлөх эрхтэй. Энэ эрхийг бодитоор хэрэгжүүлэхийн тулд иргэд хууль ямар шат дамжлагаар батлагддаг, аль шатад олон нийтийн санал авах боломж илүү байдаг, тухайн санал хэрхэн хүрдгийг ойлгож мэдэх шаардлагатай.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, баталдаг эрх зүйн баримт бичгийг үндсэн хоёр төрөлд ангилж ойлгодог.



НЭГДҮГЭЭРТ, хууль. Хууль нь тодорхой харилцааг бүхэлд нь зохицуулж, урт хугацаанд мөрдөгдөх үндсэн зохицуулалтыг тогтоодог эрх зүйн акт юм.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцдэг хуулийн төслүүдийг агуулга, зорилгоос нь хамааран хэд хэдэн төрөлд ангилдаг. Энэ нь тухайн төсөл шинэ зохицуулалт бий болгох уу, эсвэл өмнө батлагдсан хуульд өөрчлөлт оруулах уу, эсвэл хууль бүхэлдээ шинэчлэгдэж байгаа юу гэдгээс хамаарна.

1. Анхдагч хуулийн төсөл

Анхдагч хуулийн төсөл гэдэг нь өмнө нь тухайн харилцааг огт зохицуулж байгаагүй шинэ салбар, шинэ асуудлаар анх удаа хууль боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа төслийг хэлнэ. Ийм хууль нь “эхнээс нь дүрэм тогтоож байгаа” хууль юм. Энгийнээр хэлбэл, өмнө нь хууль байгаагүй шинэ асуудлыг зохицуулах гэж байгаа бол анхдагч хуулийн төсөл боловсруулна.

2. Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл

Хууль хэрэгжиж эхэлсний дараа нийгмийн байдал өөрчлөгдөх, хэрэгжилтэд хүндрэл гарах, эсвэл заалт нь тодорхой бус байх тохиолдолд тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсдэг. Ийм үед “хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл боловсруулдаг².

¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна.”

Өөрөөр хэлбэл, өмнө батлагдсан хууль хэвээр үлдэнэ, харин зарим заалтыг засах, нэмж оруулах, хасах зорилготой бол өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулдаг.

3. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

Хуульд маш олон удаа буюу хуулийн нийт заалтын 50-с дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орж, тухайн бүтэц нь ойлгомжгүй болсон, эсвэл тухайн салбарын бодлого үндсээрээ өөрчлөгдсөн үед хуульд хэсэгчилсэн засвар хийхээс илүүтэй бүхэлд нь дахин найруулж батлах шаардлага гардаг. Энэ тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулдаг³.

Энгийнээр тайлбарлавал, хууль “хуучирч”, олон засвартай болж ойлгомжгүй болсон үед түүнийг бүхэлд нь цэгцэлж, шинэ бүтэцтэйгээр дахин батлахыг шинэчилсэн найруулга гэдэг.

4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл

Зарим хууль бодит хэрэгцээгүй болох, шинэ хууль гарснаар давхцах, эсвэл тухайн харилцааг өөр хууль бүрэн зохицуулдаг болсон тохиолдолд хуучин хуулийг хүчингүй болгох шаардлага гардаг. Ийм үед “хууль хүчингүй болсонд тооцох тухай” хуулийн төсөл боловсруулна.

Ингэснээр хууль тогтоох байгууллага хуучирсан, давхардсан, хэрэгцээгүй болсон хуулийг албан ёсоор хүчингүй болгож, эрх зүйн орчныг цэгцэлдэг.

ХОЁРДУГААРТ, Улсын Их Хурлын тогтоол. Улсын Их Хурал зөвхөн хууль батлахаас гадна тодорхой асуудлаар шийдвэр гаргах хэлбэрээр “тогтоол” баталдаг.

Тогтоол нь хууль шиг бүх нийтийн байнгын зохицуулалт тогтоох бус, харин бодлого, чиглэл, зохион байгуулалт, томилгоо, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан, дүгнэлт, зөвшөөрөл зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэхэд зориулагддаг эрх зүйн акт юм. Жишээлбэл, улсын хөгжлийн бодлого батлах, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг зөвшөөрөх, байнгын хороо, ажлын хэсэг байгуулах,

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

² Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 “Хууль санаачлагч нийгмийн харилцааны төлөв байдал, тулгамдсан асуудлыг судалсны үндсэн дээр шинээр үүссэн харилцааг хуулиар зохицуулах шаардлагатай, эсхүл тухайн нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай гэж үзвэл анхдагч хуулийн төсөл боловсруулна.”

³ Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 “Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна”

25.1.1. өмнө нь тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон бол

25.1.2. хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсны улмаас хуулийн бүтэц, уялдаа алдагдахад хүрэх, эсхүл тухайн хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт орох бол

25.1.3. хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь өөрчлөхөд хүргэсэн нэмэлт, өөрчлөлт орох бол

25.1.4. тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон

албан тушаалтныг томилох, чөлөөлөх зэрэг нь тогтоолоор шийдэгддэг. Тогтоолын төслийг мөн хууль санаачлагчид санаачилж, УИХ-д өргөн мэдүүлдэг⁴.

Ийнхүү тодорхой харилцааг бүхэлд нь зохицуулж буй эрх зүйн акт болон УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь хууль тогтоомж гэж нэрлэдэг. Энгийнээр тайлбарлавал:

ХУУЛЬ



Нийгмийн харилцааг ерөнхийд нь, удаан хугацаанд зохицуулах дүрэм тогтоодог.

ТОГТООЛ



Тодорхой асуудлыг шийдвэрлэх, бодлого батлах, чиглэл өгөх, зохион байгуулалтын шинжтэй шийдвэр

ХУУЛИЙГ ХЭН САНААЧИЛДАГ ВЭ?

Хууль тогтоох үйл явцын эхний шат нь хууль санаачлах явдал юм. Хууль санаачлах эрх нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль болон Хууль тогтоомжийн тухай хуулиар тодорхой этгээдэд олгогдсон байдаг.

Хуульд⁵ зааснаар УИХ-ын гишүүд, засгийн газар болон Монгол Улсын Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй.

Гэхдээ энэ нь иргэд хууль санаачлах үйл явцад оролцох боломжгүй гэсэн үг биш юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн талаар саналаа хууль санаачлагчид уламжилж болох бөгөөд хууль санаачлагч уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно гэж заасан байдаг. Иргэд өөрсдөө УИХ-д хууль өргөн барих шууд эрхгүй хэдий ч өөрийн амьдралд тулгарч буй асуудал, орон нутгийн хэрэгцээ, бодит нөхцөлийг үндэслэн саналаа УИХ-ын гишүүн, эсвэл холбогдох яам, Засгийн газрын байгууллагад хүргүүлснээр хууль санаачлахад нөлөөлөх эрхтэй.

Орон нутгийн иргэдийн хувьд өөрсдийн тулгамдсан асуудлыг нотолгоо, үндэслэлтэйгээр хууль санаачлагчид хүргүүлэх нь хууль тогтоох үйл явцад оролцож буй хамгийн эхний, чухал алхам болдог.

⁴Хууль тогтоомжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Хууль санаачлагч Улсын Их Хурлын тогтоолыг санаачилж болно. Хуульд заасан тохиолдолд бусад байгууллага холбогдох саналаа хууль санаачлагчид уламжилна”

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйл, Хууль тогтоомжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.1

УИХ-ЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь гишүүд, чуулган, Байнгын хороо, түр хороо, ажлын хэсэг, мөн Тамгын газар гэсэн үндсэн бүтэцтэйгээр зохион байгуулагддаг.

Улсын Их Хурлын үндсэн бүрэлдэхүүн нь гишүүдээс бүрдэх бөгөөд гишүүн нь ард түмнээс сонгогдсон төлөөлөгч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг баримтлан ажиллах үүрэгтэй. Гишүүд нэгдсэн хуралдаан, Байнгын хороо, дэд хороо, ажлын хэсгийн үйл ажиллагаанд оролцож, хууль тогтоох болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Улсын Их Хурал өөрийн бүрэн эрхийг чуулганаар хэрэгжүүлэх ба чуулган нь гишүүд хууль, тогтоолын төслийг хэлэлцэж, санал хурааж, эцсийн шийдвэр гаргадаг үндсэн талбар юм. Чуулганы хуралдааны дэг, хэлэлцүүлгийн дараалал, санал хураалтын хэлбэрийг УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулсан байдаг.

Байнгын хороо

Чуулганы ажлыг бэлтгэх, хууль тогтоомжийн төслийг мэргэжлийн түвшинд урьдчилан хэлэлцэх үндсэн нэгж нь Улсын Их Хурлын Байнгын хороо юм. Байнгын хороо нь тодорхой салбар, бодлогын чиглэл хариуцан ажиллаж, тухайн хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг нарийвчлан судалж, хэлэлцэж, санал дүгнэлт боловсруулан Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд танилцуулдаг^[1]. УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэгдэх бүх асуудал холбогдох байнгын хороогоор заавал хэлэлцэгддэг.

Өөрөөр хэлбэл, Байнгын хороо нь хууль тогтоох үйл явцын “мэргэжлийн шүүлтүүр” болж, хуулийн төсөл бодит амьдралд хэрэгжих боломжтой эсэх, салбарын бодлоготой нийцэж байгаа эсэхийг урьдчилан нягталж, УИХ-ын нэгдсэн хуралдаанд бэлтгэж өгдөг чухал нэгж юм.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зааснаар Улсын Их Хурал дараах Байнгын хороодтой байна. Үүнд:

1. **Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо**-Үндэсний аюулгүй байдал, гадаад харилцаа, батлан хамгаалах, хил хамгаалахтай холбоотой бодлого, хууль тогтоомжийг хариуцна.
2. **Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо**-Байгаль орчны хамгаалалт, уур амьсгал, ус, ой, бэлчээр, хүнсний аюулгүй байдал, мал аж ахуй, газар тариалангийн бодлого, хууль тогтоомжийг хэлэлцэнэ.
3. **Төрийн байгуулалтын байнгын хороо**-Төрийн байгууллын тогтолцоо, сонгуулийн эрх зүй, нутгийн удирдлага, төрийн алба, засаг захиргааны зохион байгуулалттай холбоотой асуудлыг хариуцна.
4. **Төсвийн байнгын хороо**-Улсын төсөв, орон нутгийн төсөв, татвар, санхүү, өр зээлийн бодлого, төсвийн хяналттай холбоотой хууль тогтоомжийг хэлэлцэж, дүгнэлт гаргана.
5. **Хууль зүйн байнгын хороо**-Эрүү, иргэн, захиргааны эрх зүй, шүүх, прокурор, хүний эрх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлого, хууль тогтоомжийг хариуцна.
6. **Эдийн засгийн байнгын хороо**-Эдийн засгийн бодлого, хөрөнгө оруулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэр, тээвэр, дэд бүтэц, хувийн хэвшлийн орчинтой холбоотой асуудлыг хэлэлцэнэ.

⁶ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйл.

7. **Өргөдлийн байнгын хороо**-Иргэд, байгууллагаас УИХ-д ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн эрх зөрчигдсөн эсэхэд хяналт тавих чиг үүрэгтэй.
8. **Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо**-Боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, соёл, спорт, гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого зэрэг хүний хөгжлийн асуудлыг хариуцна.

Иймээс орон нутгийн иргэдийн хувьд өөрийн амьдралтай шууд холбоотой асуудал аль салбарт хамаарч байгаагаас шалтгаалан тухайн асуудлыг хариуцсан Байнгын хороонд санал, мэдээлэл, судалгаа, хүсэлтээ хүргүүлэх нь хууль тогтоох үйл явцад оролцох хамгийн бодит, үр дүнтэй замын нэг болдог.

Дэд болон түр хороо

Дэд хороо нь Байнгын хорооны дэргэд тодорхой салбар, асуудлыг дагнан хариуцуулан байгуулдаг мэргэжлийн бүтэц юм. Судалгаа хийх, мэдээлэл авах, албан тушаалтнаас тайлбар сонсох, ажлын хэсэг байгуулах, санал дүгнэлт боловсруулах, шаардлагатай тохиолдолд түүнийг Байнгын хороо, нэгдсэн чуулганаар хэлэлцүүлдэг.

Хянан шалгах түр хороо нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хуулийн хэрэгжилтийг шалгах зорилгоор Улсын Их Хурлаас түр хугацаагаар байгуулдаг бүтэц юм. Түр хороо нь баримт цуглуулах, шинжээч, хянан шалгагч томилох, байгууллага, албан тушаалтнаас тайлбар авах, гэрчийн мэдүүлэг сонсох замаар асуудлыг судалж, тайлан, санал, дүгнэлтээ тогтоосон хугацаанд УИХ-д танилцуулна.

Ажлын хэсэг

Тодорхой асуудлыг нарийвчлан судлах, хуулийн төсөл боловсруулах, эсхүл хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх зорилгоор УИХ Байнгын хороо, түр хороо болон ажлын хэсэг байгуулж ажиллуулдаг. Түр хороо нь хянан шалгах, тодорхой асуудлаар тусгай судалгаа хийх зорилгоор байгуулагддаг бол ажлын хэсэг нь ихэвчлэн хуулийн төсөл, тогтоолын төслийг мэргэжлийн түвшинд боловсруулах, сайжруулах, санал дүгнэлт нэгтгэх чиг үүрэгтэй ажилладаг.

Өөрөөр хэлбэл, ажлын хэсэг нь хуулийн төслийг чуулганаар шууд хэлэлцэхээс өмнө “бэлтгэх, боловсронгуй болгох” гол үүргийг гүйцэтгэж, хуулийн заалт бодит амьдралд хэрэгжих боломжтой эсэх, орон нутгийн болон иргэдийн эрх ашигт хэрхэн нөлөөлөхийг урьдчилан үнэлж, мэргэжлийн дүгнэлт гаргадаг чухал нэгж юм.

УИХ-ын тамгын газар

Улсын Их Хурлын үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, мэргэжлийн түвшинд явуулах зохион байгуулалтын болон мэдээлэл, судалгааны дэмжлэгийг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцан гүйцэтгэдэг. Тамгын газар нь УИХ-ын бие даасан нэгж бөгөөд хууль тогтоох, хянан шалгах, төлөөллийн үйл ажиллагааг гишүүд, Байнгын хороо, чуулганы түвшинд бодитоор хэрэгжих нөхцөлийг бүрдүүлж ажилладаг.

УИХ-ын бүтцийг энгийнээр тайлбарлавал:

- ард түмнээс сонгогдсон **гишүүд**,
- хууль, тогтоолыг хэлэлцэж шийдвэр гаргадаг **чуулган**,
- салбар бүрээр урьдчилсан хэлэлцүүлэг, хяналт хийдэг **Байнгын хороод** болон түүний дэргэдэх **дэд хороод**,
- тодорхой асуудлыг судалж боловсруулах **түр хороо, ажлын хэсгүүд**,
- эдгээрийн үйл ажиллагааг зохион байгуулалт, мэдээлэл, судалгаагаар хангадаг **Тамгын газар** гэсэн бүтэц, зохион байгуулалтаар хууль тогтоох болон хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлдэг байна.

ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЕ ШАТ

Хуулийн төслийг боловсруулах

Хууль тогтоох үйл явц нь хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө эхэлдэг. Энэ үед тухайн асуудлыг хуульчлах шаардлагатай эсэхийг тогтоох, судалгаа хийх, бодлогын чиглэлийг тодорхойлох, олон нийтийн санал авах, төслийн эх болон дагалдах баримт бичгийг боловсруулах зэрэг дараалсан үе шат явагддаг.

Хуулийн төсөл боловсруулахаас УИХ-д өргөн барих хүртэл дараах үе шатыг дамждаг⁷.

1. Хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын тандан судалгаа болон тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ

Хууль санаачлагч нь хуулийн төслийг боловсруулахын өмнө тухайн асуудлыг хуульчлах бодит хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тусгай аргачлалын дагуу урьдчилан судлах үүрэгтэй. Энэ судалгаагаар тухайн зохицуулалт Үндсэн хууль, олон улсын гэрээ болон хүчин төгөлдөр бусад хуультай нийцэж байгаа эсэх, уг асуудлыг заавал хуулиар зохицуулах шаардлагатай юу, ямар эрх зүйн хэм хэмжээ тогтоох ёстой вэ гэдгийг тодорхойлж, боломжит зохицуулалтын хувилбаруудын давуу ба сул талыг харьцуулан үнэлнэ. Мөн хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөг урьдчилан тооцож, хамгийн оновчтой шийдлийг сонгох үндэслэлийг боловсруулдаг.

2. Хууль тогтоомжийн үзэл баримтлалыг тодорхойлох

Үзэл баримтлал гэдэг нь тухайн хуулийг яагаад боловсруулах болсон шалтгаан, ямар зорилго тавьж байгаа, ямар харилцааг ямар хүрээнд зохицуулах, хууль батлагдсанаар эдийн засаг, нийгэм, хүний эрх, байгаль орчинд ямар нөлөө үзүүлэх, бусад хуультай хэрхэн уялдах, цаашид ямар хуулийг шинээр гаргах, өөрчлөх, хүчингүй болгох шаардлага үүсэх зэргийг цогцоор нь тайлбарласан баримт бичиг юм. Өөрөөр хэлбэл үзэл баримтлал нь “ямар асуудлыг, яагаад, ямар бодлогоор, ямар хүрээнд хуульчлах вэ” гэдгийг урьдчилан тодорхойлж, хуулийн төслийн суурь чиглэлийг тогтоодог баримт бичиг болно.

⁷ УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйл

3. Хууль тогтоомжийг боловсруулах

Хуульд⁸ зааснаар хуулийн төслийг заавал батлагдсан үзэл баримтлалын хүрээнд боловсруулна. Өөрөөр хэлбэл өмнө нь тодорхойлсон зорилго, зохицуулах хүрээ, бодлогын чиглэлийг баримтлан, хуулийн заалтуудыг нэг бүрчлэн найруулж, хууль зүйн техник, бүтэц, хэлбэрийн шаардлагад нийцүүлэн төслийг бэлтгэнэ.

4. Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцооллыг хийх

Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө түүний нийгэм, эдийн засаг, эрх зүйн болон хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг заавал урьдчилан үнэлүүлдэг. Энэ үнэлгээг хууль санаачлагч нь хөндлөнгийн, бие даасан судлаач, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлж, тусгай аргачлалын дагуу хуулийн төслийн зохицуулалт бодит амьдралд хэрэгжих боломжтой эсэх, бусад хуультай зөрчилдөх, давхцах, хийдэл үүсгэх эрсдэл байгаа эсэх, урьдчилан тооцоогүй сөрөг үр дагавар гарах магадлал, хүний эрх, эрх чөлөөнд хэрхэн нөлөөлөхийг нарийвчлан шинжилж дүгнэлт, зөвлөмж гаргуулна.

Хууль санаачлагч нь тухайн хууль батлагдсанаар улсын төсөвт ямар зардал нэмэгдэх, мөн иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагад ямар санхүүгийн дарамт, зардал үүсэхийг тооцож, зардал ба үр өгөөжийн харьцааг үнэлэх ёстой.

5. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах

Хуульд⁹ зааснаар хууль санаачлагч нь хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө заавал олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэгтэй. Үүний тулд хуулийн төсөл болон түүний үзэл баримтлал, танилцуулга, судалгаа, үр нөлөөний үнэлгээ зэрэг холбогдох баримт бичгийг өөрийн албан ёсны цахим хуудас болон хуулийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулж, санал өгөх хугацааг тодорхой зарлана. Санал авах хугацаа нь ердийн тохиолдолд 15-аас доошгүй хоног байх бөгөөд иргэн, хуулийн этгээд саналаа бичгээр болон цахим хэлбэрээр өгөх боломжтой.

Олон нийтийн хэлэлцүүлгийг бичгээр санал авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга явуулах, цахим хэлэлцүүлэг хийх зэрэг олон хэлбэрээр явуулж болно. Ялангуяа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөх иргэн, аж ахуйн нэгжийн төлөөллөөс заавал санал авч, тэдгээрийг төслийн бүрдүүлбэрт хавсаргах зохицуулалттай. Хэлэлцүүлэг дууссаны дараа хууль санаачлагч нь ирсэн саналуудыг хэрхэн тусгасан, эс тусгасан талаарх тайлбар, үндэслэлийг 30 хоногийн дотор цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлэх үүрэгтэй. Ингэснээр иргэд хуульд ямар санал нь туссан, яагаад зарим санал хүлээн авагдаагүйг ил тод мэдэх боломж бүрддэг.

Хуулийн төслийн энэ үе шатад иргэд, олон нийтийн оролцоо хамгийн их хангагдах боломжтой байдаг.

6. Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах

Хууль санаачлагч нь хуулийн төслийг боловсруулахдаа уг хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэгтэй болон холбогдох мэргэжлийн байгууллагуудаас, түүнчлэн хүний эрх, шүүх, прокурорын байгууллага зэрэг тусгай байгууллагуудаас заавал санал авч, тэдгээрийн бичгээр буюу цахимаар ирүүлсэн дүгнэлтийг төслийн бүрдүүлбэрт багтааснаар хуулийн төсөл нь бодит хэрэгжилт, хүний эрх, байгууллагын чадамжтай нийцэх эсэхийг урьдчилан нягталсан, олон талын мэргэжлийн үндэслэлтэй баримт бичиг болдог.

⁸ Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйл

⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйл

7. Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх

Хэрэв хуулийн төслийг Засгийн газар санаачилж байгаа бол тухайн төслийг боловсруулсан яам нь бусад холбогдох яам, агентлагаас албан ёсоор санал авч хянуулна. Эдгээр байгууллага нь төслийг Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, төсвийн чадамжтай нийцэж байгаа эсэхийг шалгаж, шаардлага хангаагүй бол буцаах, засварлуулах, эсхүл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгох шийдвэр гаргадаг.

Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн хуулийн төсөл санаачилсан тохиолдолд мөн адил төслийг Засгийн газарт хүргүүлж, тэндээс албан ёсны санал, дүгнэлт авч засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлдэг. Хэрэв Засгийн газар уг төслийг дэмжих боломжгүй гэж үзвэл энэ тухай үндэслэлтэй дүгнэлтийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах ёстой.

8. УИХ-д өргөн мэдүүлэх

Хууль санаачлагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ зөвхөн төслийн эхийг бус, Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан бүрдүүлбэрийг бүрэн хангаж ирүүлэх үүрэгтэй. Үүнд төслийг өргөн мэдүүлэх тухай албан бичиг, төслийн үзэл баримтлал, хэрэгцээ шаардлагын судалгаа буюу хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо, төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулга, дагалдах өөрчлөлтийн төслүүд, олон нийтийн хэлэлцүүлгээр ирсэн саналуудын нэгтгэл, түүнчлэн шаардлагатай тохиолдолд Засгийн газрын санал, зөвшөөрөл, хууль зүйн дүгнэлт зэрэг баримт бичиг багтана. Эдгээр нь хуулийн төсөл бодлогын үндэслэлтэй, судалгаанд тулгуурласан, хэрэгжих боломжтой эсэхийг нотлох үүрэгтэй.

Хуулийн төслийг хэлэлцэн батлах

Хууль санаачлагч бүрдүүлбэрээ бэлтгэсний дараа өргөн мэдүүлэх тов тогтоолгох тухай албан бичгийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлж, Тамгын газар төслийн бүрдүүлбэрийг хуульд заасан шаардлага хангаж байгаа эсэхийг шалгана. Үүгээр төсөл үзэл баримтлалын хүрээнд боловсруулагдсан эсэх, хэрэгцээ шаардлагын судалгаа болон үр нөлөө, зардлын тооцоо хийгдсэн эсэх, хууль санаачлах эрхийн хүрээнд багтаж байгаа эсэхийг нягталж, шаардлага хангаагүй бол засварлуулах зорилгоор буцаах, харин шаардлага хангасан бол УИХ-ын даргад өргөн мэдүүлэхэд бэлэн гэж үзэн тов тогтоодог.

Хууль санаачлагч хуулийн төслөө Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дараа уг төсөл шууд батлагддаггүй, хэд хэдэн шат дамжлагатайгаар хэлэлцэгддэг. Энэ үе шатыг хууль тогтоох үйл явцын хамгийн чухал хэсэг бөгөөд хуулийн агуулга сайжрах, олон талын санал тусах боломж энд бүрддэг.

1. Хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг

Хууль санаачлагч хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсний дараа тухайн төслийг шууд заалт бүрээр нь хэлэлцдэггүй. Эхлээд уг төслийг зарчмын хувьд хэлэлцэх шаардлагатай эсэх, өөрөөр хэлбэл энэ асуудлыг хуульчлах нь зүйтэй юу, санал болгож буй бодлогын чиглэл зөв үү гэдгийг шийдвэрлэдэг үе шат явагдана. Үүнийг хуулийн төсөл “үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг шийдэх шат” гэж ойлгож болно.

УИХ-ын дарга тухайн асуудлыг холбогдох байнгын хороонд хуваарилснаар тухайн байнгын хороо хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж нэгдсэн хуралдаанд танилцуулдаг. Ингээд байнгын хорооны санал дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж хариулт авах замаар хэлэлцүүлэг өрнөдөг.

2. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг УИХ дэмжсэн тохиолдолд дараагийн шат болох анхны хэлэлцүүлэг эхэлдэг. Энэ шатад хуулийн төслийг ерөнхийд нь бус, харин зүйл, заалт бүрээр нь нарийвчлан авч үзэж, агуулгыг бодитоор хэлэлцэж эхэлдэг.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг нь эхлээд холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэгддэг. УИХ-ын дарга хуулийн төслийг эрхлэх асуудлынх нь хүрээнд нэг буюу хэд хэдэн Байнгын хороонд хуваарилсны дараа тухайн Байнгын хороо анхны хэлэлцүүлгийг зохион байгуулж, төслийн заалт бүрийг нэг бүрчлэн хэлэлцдэг.

Байнгын хорооны анхны хэлэлцүүлгийн явцад байнгын хорооны гишүүд тухай хуулийн төслийн зарим зүйл заалтыг өөрчлөхөөр гаргасан саналыг зарчмын зөрүүтэй санал гэх ба байнгын хороо гишүүдээс гарсан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эдгээрийг нэгтгэсэн байнгын хорооны санал дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулж, гишүүд хуулийн төслийн зүйл, заалт бүрээр асуулт асууж, санал хэлж, зарим заалтад өөрчлөлт оруулах эсэхийг хэлэлцдэг. Нэгдсэн чуулганы хуралдаанаар байнгын хорооны хуралдаанаас гарсан байнгын хорооны дэмжсэн эсхүл дэмжээгүй зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлдэг.

Энгийнээр хэлбэл, анхны хэлэлцүүлэг гэдэг нь хуулийн төслийг “заалт заалтаар нь задлан шинжилж, засварлах” шат юм. Байнгын хорооны түвшинд мэргэжлийн нарийвчилсан хэлэлцүүлэг явагдаж, түүний дүгнэлт нэгдсэн хуралдаанд орж, бүх гишүүдийн өмнө нээлттэй хэлэлцэгддэг.

3. Эцсийн хэлэлцүүлэг

Эцсийн хэлэлцүүлэг нь эхлээд холбогдох Байнгын хорооны хуралдаанаар явагдана. Энэ шатад Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр нэгдсэн хуралдаанаас дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналуудыг хуулийн төслийн найруулгад тусгаж, дэмжигдээгүй саналуудыг хасаж, төслийн заалтуудын уялдаа холбоо, найруулга, бүтэц, хууль зүйн техникийн алдааг засварлан эцсийн найруулгыг бэлтгэнэ. Өөрөөр хэлбэл, анхны хэлэлцүүлгээр “ямрыг нь өөрчлөх, алийг нь хэвээр үлдээх” гэдэг нь нэгэнт шийдэгдсэн тул эцсийн хэлэлцүүлгээр тухайн шийдвэрүүдийг нэг мөр болгон цэгцэлж, хуулийг батлахад бэлэн найруулгад оруулахад анхаарна. Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгээр анхны хэлэлцүүлгээр гарсан бүх санал хуулийн төсөлд зөв туссан эсэхийг шалгаж, найруулгын зөрчил, давхардал, ойлгомжгүй томъёоллыг засварлаж, эцсийн найруулгыг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийг боловсруулна.

Үүний дараа хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэгт оруулна. Нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулж, гишүүд төслийн эцсийн найруулгыг бүхэлд нь авч үзэн, анхны хэлэлцүүлгээр гарсан шийдвэрүүд зөв туссан эсэх, найруулга ойлгомжтой, хэрэгжих боломжтой болсон эсэхийг хэлэлцэнэ. Энэ шатад зарчмын хувьд шинэ бодлогын маргаан үүсгэх бус, харин өмнөх шатнуудаар шийдвэрлэсэн асуудлуудыг нэг мөр болгож, хуулийн төслийг батлахад бэлэн эцсийн хэлбэрт оруулах зорилготой байдаг.

Хэрэв Байнгын хорооноос эцсийн найруулгатай холбоотой зарчмын зөрүүтэй санал нэгдсэн хуралдаанд оруулсан бол түүний талаар гишүүд санал хураалт явуулж, шийдвэр гаргана. Ингэсний дараа хуулийн төслийг эцэслэн батлах шатад оруулах бэлтгэл хангагдаж, холбогдох Байнгын хороонд шилжүүлдэг.

Энгийнээр хэлбэл, эцсийн хэлэлцүүлэг гэдэг нь хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээр гарсан бүх санал, шийдвэрт нийцүүлэн эцэслэн цэгцэлж, хууль зүйн болон бодлогын хувьд алдаагүй, ойлгомжтой, хэрэгжих боломжтой найруулгад оруулж дуусгаад, хуулийг эцэслэн батлахад бэлэн болгох үе шат юм.

4.Эцэслэн батлах

Хуулийн төслийг анхны болон эцсийн хэлэлцүүлгээр бүх заалтыг нь нэг бүрчлэн хэлэлцэж, засварлаж дууссаны дараа түүнийг эцэслэн батлах асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцэнэ. Энэ шатад хуулийн төслийг дахин заалт бүрээр нь маргахгүй, харин эцсийн найруулгаар нь бүхэлд нь батлах эсэхийг шийддэг.

Эцсийн хэлэлцүүлгийн дараа бэлтгэсэн хуулийн төслийн эцсийн найруулгыг нэгдсэн хуралдаанд оруулж, гишүүдэд танилцуулах ба үүний дараа хуулийн төслийг эцсийн найруулгаар нь бүхэлд нь батлах эсэх талаар санал хураалт явуулж хэрэв нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжвэл уг хуулийн төсөл батлагдсанд тооцогдоно. Харин олонх дэмжихгүй бол хуулийн төсөл батлагдахгүй ба түүнийг хууль санаачлагчид нь буцаах тухай УИХ-ын тогтоол баталсанд тооцно.

Хууль батлагдсаны дараа УИХ-аас баталсан хуулийг хуульд заасан журмын дагуу албан ёсоор баталгаажуулж, Ерөнхийлөгчид хүргүүлэх, нийтлэх ажиллагаа хийгдэж, ингэснээр хууль хүчин төгөлдөр болох дараагийн шатад шилжинэ.

Энгийнээр хэлбэл, эцэслэн батлах шат гэдэг нь олон шат дамжлагаар хэлэлцэж, засварласан хуулийн төслийг “улсын хэмжээнд мөрдөх хууль болгох уу, үгүй юу” гэдгийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар санал хураалтаар нэг мөр шийддэг хамгийн сүүлийн үе шат юм.

Эцэст нь

Энд тайлбарласанчлан хуулийн төсөл нь шууд батлагддаггүй. Харин “хэлэлцэх эсэх”-ийг шийдэх, “анхны хэлэлцүүлэг”, “эцсийн хэлэлцүүлэг”, “эцэслэн батлах” гэсэн үе шатаар дамжиж байж шийдвэрлэгддэг. Энэ шат бүрд Байнгын хороо, нэгдсэн чуулган, ажлын хэсэг оролцож, төслийн агуулгыг нягталж, санал хураалтаар шийдвэр гаргадаг. Ийм олон шаттай хэлэлцүүлгийн зорилго нь хуулийг бодит нөхцөлд нийцсэн, хэрэгжих боломжтой, иргэдийн эрх ашигт нийцэх байдлаар сайжруулах явдал юм. Тиймээс иргэдийн хувьд хуулийн төсөл аль шатад явж байгааг мэдэж байх нь санал бодлоо зөв цагт, зөв газарт хүргэхэд тусалдаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хуулийн төслийг боловсруулах үе шатад
иргэд хэрхэн оролцож болох вэ?

АГУУЛГА

- Хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлгээр дамжуулж иргэдийн оролцоог дэмжих алхамчилсан заавар
- Цахимаар хуулийн төсөлд санал өгөх алхамчилсан заавар
- Албан бичгээр санал хүргүүлэх алхамчилсан заавар
- УИХ-ын гишүүнээр дамжуулж санал хүргүүлэх алхамчилсан заавар

УИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө буюу боловсруулах үед иргэдийн оролцоо хамгийн бодитой хэрэгжих боломжтой байдаг. Учир нь энэ үед хууль санаачлагч тухайн асуудлыг хуульчлах шаардлага байгаа эсэхийг судалж, ямар бодлого, ямар зохицуулалтаар шийдэх вэ гэдгээ тодорхойлж, төслийн заалтуудыг нэг бүрчлэн найруулж боловсруулдаг. Иймээс иргэдийн санал зөв цагтаа хүрвэл хуулийн төслийн агуулгад шууд тусах боломж харьцангуй өндөр байдаг.

Нэгдүгээрт, иргэд тодорхой нэг асуудлаар хуулийн төсөл санаачлах саналыг хууль санаачлагчид хүргүүлж болно. Хууль тогтоомжийн тухай хуульд иргэн, хуулийн этгээд хуулийн төслийн талаар саналаа хууль санаачлагчид уламжилж болох бөгөөд хууль санаачлагч уг саналыг үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно гэж заасан. Өөрөөр хэлбэл иргэд өөрсдөө УИХ-д хууль өргөн барих шууд эрхгүй ч амьдрал дээр тулгамдаж буй асуудлаа баримт, үндэслэлтэйгээр боловсруулж, УИХ-ын гишүүн, Засгийн газар, Ерөнхийлөгч зэрэг хууль санаачлах эрхтэй этгээдэд хүргүүлснээр хууль санаачлах шийдвэр гаргахад нөлөөлөх боломжтой гэсэн үг.

Хоёрдугаарт, хууль санаачлагч нь олон нийтийн оролцоог хангах зорилгоор төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах механизмыг ашигладаг. Хуулиар олон нийтийн хэлэлцүүлгийг бичгээр санал авах, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга явуулах, цахим хэлбэрээр хэлэлцүүлэг явуулах зэрэг хэлбэрээр явуулж болно гэж тодорхойлсон байдаг. Иймээс иргэд зөвхөн нэг сувгаар бус, тухайн асуудлын онцлог болон өөрийн боломжид тохируулан санал өгөх боломжтой.

Гуравдугаарт, иргэдийн оролцоог бодит болгодог хамгийн чухал нөхцөл нь санал өгөөд төгсөх бус, өгсөн санал нь хэрхэн шийдэгдсэнийг мэдэх боломж юм. Хууль тогтоомжийн тухай хуульд олон нийтийн хэлэлцүүлгээр ирүүлсэн саналыг хууль санаачлагч харгалзан үзнэ гэж зааснаас гадна, ирсэн саналуудыг хэрхэн тусгасан, эс тусгасан болон түүний шалтгаан, үндэслэлийг тодорхой байдлаар мэдээлэх үүрэгтэй уялддаг. Ингэснээр иргэд “миний санал туссан уу, яагаад тусгаагүй вэ” гэдгийг мэдэх, шаардлагатай бол саналаа илүү нотолгоотой, үндэслэлтэй болгон дахин хүргүүлэх боломжтой болдог.

Дөрөвдүгээрт, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох боломжийг орон зай, цаг хугацаанаас үл хамааран хангах зорилгоор хуулийн төслийн талаар санал авах нэгдсэн цахим системийг ашиглахаар хуульд зохицуулсан. Энэ нь ялангуяа орон нутгийн иргэдийн хувьд чухал ач холбогдолтой бөгөөд хуулийн төслийн эх бичвэр, үзэл баримтлал, судалгаа, үр нөлөөний үнэлгээ зэрэг материалтай цахимаар танилцах, өөрийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр хүргүүлэх бодит боломжийг бүрдүүлдэг. Үүний хүрээнд хууль санаачлагч нь хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан, хууль тогтоомжийг товч болон дэлгэрэнгүй танилцуулга, дагалдан өөрчлөгдөх хуулийн төслүүдийг хуулийн төсөлтэй хамт цахим системд байршуулж, иргэд, хуулийн этгээдээс 15-аас доошгүй хоногийн хугацаанд санал авахаар зохицуулсан байдаг. Иргэдийн оролцоо нь мэдэх эрх дээр суурилдаг тул санал өгөхийн өмнө хуулийн төслийн агуулга, зорилго, үндэслэл, холбогдох судалгаа, үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг мэдээлэлтэй танилцах шаардлагатай. Ийм мэдээлэл ил тод, нээлттэй байснаар иргэд тухайн хуулийн төсөл өөрсдийн амьдрал, эрх ашигт хэрхэн нөлөөлөхийг ойлгож, үндэслэлтэй, бодитой санал гаргах нөхцөл бүрддэг.

Иймээс дүгнэж хэлбэл, иргэд хууль санаачлах, боловсруулах үе шатад саналаа хууль санаачлагчид хүргүүлэх, төслийн агуулгад санал өгөх, олон нийтийн хэлэлцүүлэгт оролцох, цахимаар санал хүргүүлэх, мэдээлэл авч үндэслэлтэй байр суурь илэрхийлэх зэрэг олон хэлбэрээр оролцох боломжтой бөгөөд энэ шатад оролцоо сайн хангагдвал хуулийн төсөл бодит хэрэгцээ, орон нутгийн нөхцөл, иргэдийн эрх ашигт илүү нийцсэн хэлбэрээр УИХ-д өргөн мэдүүлэх боломж бүрддэг.

ХУУЛИЙН ТӨСӨЛД ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГЭЭР ДАМЖУУЛЖ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ АЛХАМЧИЛСАН ЗААВАР

Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг гэж юу вэ?

Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг гэдэг нь хууль тогтоох явцад боловсруулагдаж буй хуулийн төсөлд иргэд, иргэний нийгмийн байгууллага, судлаачид, мэргэжилтнүүд саналаа чөлөөтэй илэрхийлэх, оролцох боломжийг олгодог нээлттэй үйл явц юм.

Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийн үр нөлөө

Хууль тогтоох үйл ажиллагааны чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх үндсэн механизм нь хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх (public consultation on draft law) билээ. Хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх нь олон талын мэдээлэл, судалгаа, байр суурийг үндэслэн түүний чанарыг сайжруулах, зөвшилцлийг бий болгож хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах зэрэг үр нөлөөтэй. Олон нийтийн хэлэлцүүлгийн нэн тэргүүний зорилго нь хууль тогтоомжийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлж, нээлттэй, ардчилсан арга замаар шийдвэр гаргах явдлыг дэмжихэд оршино.¹⁰

Хууль санаачлагчийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахтай холбоотой үүрэг

Хууль тогтоомжийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх үйл явцад тавигдах шаардлага	Хуулийн холбогдох зохицуулалт
Олон нийтэд танилцуулахаар нийтлэх: - Хуулийн төсөл болон дагалдах баримт бичгийг албан ёсны цахим хуудаст байршуулж, санал авах хугацааг тодорхой заах - Худалдаа, хөрөнгө оруулалт, татвар зэрэг бизнесийн орчинд нөлөөлөх хууль тогтоомжийг төслийг 60-с доошгүй, бусад хууль тогтоомжийн төслийг 15-с доошгүй хоног байршуулах	38.2
Санал авах: - Иргэд, хуулийн этгээдээс бичгээр болон цахим хэлбэрээр санал авах - Хууль санаачлагч нь саналыг харгалзан үзэх үүрэгтэй	38.3, 38.4, 38.5
Олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэр: Бичгээр санал авах, биечилсэн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга явуулах, цахим хэлбэрээр хэлэлцүүлэг явуулах болон бусад хэлбэр.	38.6
Саналыг тусгах эсэхийг шийдвэрлэн эргэж мэдээлэх: Олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссанаас хойш 30 хоногийн дотор саналыг хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй эсэх тухай саналын товъёг бэлтгэн албан ёсны цахим хуудаст байршуулах	38.7

¹⁰ Р. Оюундэлгэр, Б. А. (2025). Хууль, тогтоомжийн төслийн ил тод байдал ба олон нийтээр хэлэлцүүлэх шаардлагын хэрэгжилт. Улаанбаатар: Нээлттэй Нийгэм Форум.
https://forum.mn/uploads/users/3092/files/NNF_huuli_togtoomj_HEWLELTED.pdf

Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэгт иргэн миний бие яаж оролцох вэ?

Олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэр нь зөвхөн биечилсэн уулзалт, хэлэлцүүлгийг хэлэхгүй ба иргэн та бичгээр саналаа өгөх, цахимаар хэлбэрээр хэлэлцүүлэгт оролцох, санал асуулгад саналаа өгөх гээд олон хэлбэрээр хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох боломжтой.

1. Хуулийн төслийн хүрээнд УИХ, байнгын хороо, ажлын хэсгээс **олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг, уулзалт, сонсгол** зохион байгуулдаг. Иргэн та:
 - Эдгээр арга хэмжээний зар, мэдээллийг парламентын албан ёсны сайт <https://www.parliament.mn> болон олон нийтийн сүлжээнээс авч,
 - Оролцохоор бүртгүүлэн, санал бодлоо шууд илэрхийлэх боломжтой.
2. Иргэд хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэгт **D-Parliament (d.parliament.mn)** цахим платформоор дамжуулан оролцож болно. Үүний тулд:
 - Платформд нэвтэрч (e-Mongolia / ДАН-аар),
 - Олон нийтийн санал авч буй хуулийн төслийг сонгон,
 - Төслийн агуулгатай танилцсаны дараа саналаа бичиж, дэмжих эсвэл өөрчлөх байр сууриа илэрхийлнэ.

Ингэснээр таны санал хууль тогтоох явцад албан ёсоор бүртгэгдэж, холбогдох ажлын хэсэг, байнгын хороодын түвшинд хэлэлцэгдэх боломж бүрдэнэ.

3. Мөн та УИХ, холбогдох байнгын хороо, ажлын хэсэгт албан бичгээр өөрийн саналыг хүргүүлж, хуулийн төсөлд тусгах шаардлагатай өөрчлөлт, үндэслэлийг баримттайгаар тайлбарлах боломжтой.

ХУУЛИЙН ТӨСӨЛД ЦАХИМААР САНАЛ ӨГӨХ АЛХАМЧИЛСАН ЗААВАР



Хууль тогтоох үйл явц нь зөвхөн улс төрчид, хууль санаачлагчдын оролцоогоор хязгаарлагдах бус, **иргэд бидний санал бодол, оролцоонд тулгуурлах ёстой**. Иргэн бүр хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх шатнаас нь эхлэн өөрийн байр сууриа илэрхийлэх, санал өгөх боломжтой бөгөөд энэ нь ардчилсан нийгмийн чухал илэрхийлэл юм. Энэхүү оролцоог бодитоор хэрэгжүүлэх боломжийг D-Parliament цахим платформ олгодог.

D.parliament.mn нь Монгол Улсын Их Хурлын дэргэдэх D-Parliament буюу цахим парламентын платформ бөгөөд иргэд олон нийт хууль тогтоох үйл явцад цахимаар оролцох боломжийг бүрдүүлэх зорилготой сайт юм. Тус платформоор дамжуулан УИХ-д өргөн баригдсан хуулийн төслүүдтэй танилцах, төсөлд санал өгөх, онлайн хэлэлцүүлэгт оролцох, санал хүсэлт, өргөдөл илгээх боломжтой. Ингэснээр парламентын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэдийн санал бодлыг хууль тогтоох шатнаас нь эхлэн тусгах нөхцөлийг бүрдүүлдэг оролцооны чухал хэрэгсэл юм.

Тэгвэл иргэд бид хуулийн төсөлд хэрхэн саналаа өгөх вэ?

The left screenshot shows the Parliament app's login screen. It features the Parliament logo at the top, a 'НЭВТРЭХ' (Login) button, and input fields for 'И-мэйл' (Email) and 'Нууц үг' (Password). Below the input fields is a green 'НЭВТРЭХ' button. At the bottom, there is a link 'Нууц үгээ мартсан?' (Forgot your password?) and a 'Бүртгүүлэх' (Register) link.

The right screenshot shows the Parliament app's registration screen. It features the Parliament logo at the top, a 'БҮРТГҮҮЛЭХ' (Register) button, and input fields for 'И-Мэйл' (Email), 'Нууц үг' (Password), and 'Нууц үг давтах' (Repeat password). Below the input fields is a checkbox for 'Би үйлчилгээний нөхцлийг зөвшөөрч байна. Үйлчилгээний нөхцөл' (I agree with the terms of service. Terms of service). At the bottom, there is a green 'БҮРТГҮҮЛЭХ' button and a 'Нэвтрэх' (Login) link.

1-р алхам: Системд нэвтрэх

- <https://d.parliament.mn/> хуулийн төслийн санал авдаг албан ёсны платформд нэвтрэнэ.
- “Нэвтрэх” товчийг дарна. Бүртгэлгүй бол “Бүртгүүлэх” товчийг дарж бүртгүүлнэ.
- Үүний дараа ДАН / e-Mongolia / тоон гарын үсэг ашиглан баталгаажуулалт хийнэ.

2-р алхам: Хуулийн төсөл хайх



БОЛОВСРУУЛЖ БУЙ ТӨСЛҮҮД

ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

- “Боловсруулж буй төслүүд”, “Өргөн барьсан төслүүд” хэсгийг сонгоно.
- Санал өгөх гэж буй хуулийн төслийн нэр, дугаараар хайна.

The screenshot shows the Parliament website's interface for viewing bills. At the top, there are navigation tabs: 'БҮГД' (All), 'ЕРӨНХИЙЛӨГЧ' (Chairman), 'УИХ-ЫН ГИШҮҮД' (Members of the State Great Khural), 'ЗАСГИЙН ГАЗАР' (Government), 'БУСАД' (Others), and 'АЛ ДҮН ШИНЖИЛГЭЭ' (Analysis). Below the tabs, there is a search bar and a dropdown menu. The main content area displays a list of bills under the heading 'БОЛОВСРУУЛЖ БУЙ ТӨСЛҮҮД'. Each bill card includes a profile picture of the proposer, their name, the title of the bill, a 'САНАЛ ӨГӨХ' (Vote) button, and the number of votes. The bills listed are:


- Доржзавын ЭНХТУЯА: ЗАСГИЙН ГАЗАРТ ЧИГЛЭЛ ӨГӨХ ТУХАЙ (On the approval of the Government)
- Одонгийн ЦОГТГЭРЭЛ: ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ (On the economic rights and freedoms)
- Жаргалсайханы ЗОЛЖАРГАЛ: МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, (On the consolidation of the laws of Mongolia, the local government, and the local government)
- Бадмдоржийн ПУНСАЛМАА: УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ (On the consolidation of the laws of Mongolia, the local government, and the local government)
- Хүрэлбаатарын БААСАНЖАРГ...: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ (On the consolidation of the laws of Mongolia, the local government, and the local government)

3-р алхам: Хуулийн төслийг уншиж танилцах

Тухайн хуулийн төслийн доор гарах “Санал өгөх” товчийг дарж ороод хуулийн төслийн:

- Үзэл баримтлал
- Танилцуулга
- Хуулийн төсөл
- Судалгаа тооцоо
- Хавсралт материалуудтай танилцана.


Санал өгөхөөс өмнө төслийг бүрэн уншихыг зөвлөж байна.



4-р алхам: Санал бичих

- “Санал өгөх” эсвэл “Сэтгэгдэл бичих” хэсгийг сонгоно. Зүйл заалт тус бүр дээр санал дэмжиж байгаа, дэмжихгүй байгааг илэрхийлэх тэмдгүүд байгаа тул заавал сэтгэгдэл бичих шаардлагагүйгээр дэмжиж дэмжихгүй байгаагаа илэрхийлж ч болно. Энэ хоёр тэмдэг нь “Facebook”-ийн like болон angry эможитэй төстэй гэж ойлгоход болно.

тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг.



- Саналаа бичих бол дараах хоёр тэмдгийг хажууд байрлах тэмдгийг дарж бичнэ. Та өөрийн саналыг бичихдээ тухайн хуулийн төслийг эсвэл тухайн хуулийн төсөл дэх зүйл заалтыг:
 - дэмжиж байгаа эсэх
 - өөрчлөх санал
 - нэмэх, хасах заалтын тухай товч, ойлгомжтой бичнэ.

1.1. Энэ хуулийн зорилго нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө, төр нь өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах зарчимд тулгуурлан хувь хүний эдийн засгийн суурь эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулах, хувийн өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, хөдөлмөр ба хөрөнгө оруулалтын үр шимийг хамгаалах, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог хязгаарлах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой орчныг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

* Таны санал

ийм учраас санал нийлэхгүй байна, ингэж сайжруулалт хийвэл зохилтой гэх мэтээр ойлгомжтой байдлаар бичих

Үгүй Хадгалах

3.1. Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хуулиар хориглосноос бусад төрлийн эдийн засгийн харилцаанд хамаарна.

Санал бичих

Н НОМИН-ЭРДЭНЭ С

Хариулах 2026.01.21 103.229.123.62

5-р алхам: Саналаа илгээх

- Бичсэн саналаа шалгаад “Хадгалах” товчийг дарна.
- Амжилттай илгээгдсэн бол ингэж гарч ирнэ.
- Өөрийнхөө бичсэн саналуудыг мөн дараах хэсгээс харах боломжтой.

МИНИЙ МЭДЭЭГЭЛ
МИНИЙ ДАГАСАН
МИНИЙ САНАЛУУД

МИНИЙ САНАЛУУД

Н НОМИН-ЭРДЭНЭ С
2026.01.21 103.229.123.62

Н НОМИН-ЭРДЭНЭ Й
2026.01.21 103.229.123.62

Н НОМИН-ЭРДЭНЭ Д
2026.01.21 103.229.123.62

6-р алхам: Саналын хэрэгжилтийг хянах

- Таны илгээсэн хуулийн төслийн саналын хариуг та дараах байдлаар авах боломжтой. “Өргөн мэдүүлсэн хуулиуд” цэс рүү орж өөрийн санал өгсөн хуулийн төслөө хайлт хэсэг бичиж хайна.
- Хуулийн төсөл рүүгээ дарж орон хамгийн доор байрлах хэсгээс “Өргөн мэдүүлэх-Бусад” цэсэд саналын товьёг эсвэл Хуулийн төсөлд ирүүлсэн санал гэх мэт гарчигтай файл орсон бол тэнд иргэдийн ирүүлсэн саналыг хэрхэн хэлэлцсэн, тухайн хуульд юу тусгасан, тухайн иргэний саналыг яагаад тусгаагүй зэргээ танилцуулсан байдаг.

ТӨСЛИЙН ФАЙЛУУД

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -ТУХАЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛЖ БАЙГАА ХУУЛЬ ТОГТОМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

ӨРГӨН МЭДҮҮЛЭХ -БУСАД

(5.ААНОАТ хуулийн төслийн үр нөлөө (2025.12).docx)

(7.ААНОАТ-Саналын товьёг.docx)


Анхаарах зүйлс

- Зүй бусаар доромжилсон, тухайн хуулийн төсөлтэй хамааралгүй агуулгатай санал хүлээн зөвшөөрөгдөхгүй
- Аль болох үндэслэлтэй, тодорхой санал бичих нь үр дүнтэй шүү.

Илүү дэлгэрэнгүй тайлбарласан бичлэгийг та дараах QR кодыг утсаараа уншуулж үзээрэй.



Мөн та аливаа нэг асуудлаар <https://d.parliament.mn/> сайтад хандаж “Нийтийн өргөдөл” хэсгээр дамжуулж өргөдөл гаргах боломжтой. Тухайн өргөдөл 100,000 хүний санал авсан тохиолдолд УИХ-аар орж хэлэлцүүлэгддэг. Та өргөдөл санаачлахгүй байсан ч гаргасан өргөдлүүдээс санал нийлж буй өргөдлүүддээ дуу хоолойгоо нэгтгэн гарын үсгээ цахимаар зурах боломжтой.



АЛБАН БИЧГЭЭР САНАЛ ХҮРГҮҮЛЭХ АЛХАМЧИЛСАН ЗААВАР

Байгууллага хооронд болон бусад холбогдох хуулийн этгээдтэй албаны аливаа асуудлаар харилцсан бичиг баримтыг албан бичиг гэнэ¹¹. **"ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ"** хуульд зааснаар иргэн таны хүргүүлэх албан бичгүүдийн төрлүүдээс дурдвал:

- **"өргөдөл"** гэж энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх заалтад зааснаас бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг; Өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно.
- **"санал"** гэж төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар гаргасан иргэний хүсэлтийг;
- **"мэдэгдэл"** гэж Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэдээс гаргасан хүсэлтийг;
- **"гомдол"** гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг; хэлдэг байна.

Иргэн та төрийн байгууллага, тодорхой албан тушаалтанд өргөдөл гомдол илгээх эсвэл хуулийн төслийн талаар саналаа илэрхийлэхэд албан бичиг хүргүүлэх бол дараах хэдэн аргаар хүргүүлэх боломжтой.

- Биечлэн тухайн албанд очиж өгөх
- Мэйл хаягаар нь албан бичиг хүргүүлэх
- Шуудангаар илгээх

Албан бичгийг та үйлдэхдээ дараах хуулийн заасан гол зарчмыг баримтлах хэрэгтэй.

- Бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан өргөдөл, гомдолд овог, нэр оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичиж, гарын үсгээ зурна. Хүндэтгэн үзэх шалтгаанаар гарын үсгээ зурж чадахгүй бол бусдаар төлөөлүүлэн зурж болно.
- Өргөдөл, гомдлыг иргэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хамтран гаргасан бол түүнд бүгд гарын үсэг зурах буюу эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргана.
- Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалж болохгүй.
- Өргөдөл, гомдол үнэн зөв байна.

¹¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Боловсролын Үндэсний Зөвлөл. (n.d.). Retrieved from nairuulga.mn: <https://nairuulga.mn/content/11>

Хариу, явцыг хянах

- Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг тухайн байгууллагын удирдах албан тушаалтан 30 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.
- Саналын шинжтэй өргөдлийн хариуг 90 хоногт багтаан өгнө.
- Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдлын талаархи шийдвэрийг зөвшөөрөхгүй тохиолдолд гомдол гаргах эрхтэй. Гомдлыг тухайн захиргааны актыг гаргасан байгууллага, албан тушаалтны дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд, дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй бол тухайн захиргааны актыг гаргасан байгууллагад, эсхүл гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана.

Дээрх хуулийн талаар илүү дэлгэрэнгүй уншихыг хүсвэл дараах QR уншуулж үзээрэй.



Албан бичиг бичих стандарттай доорх холбоосуудаар орж танилцах боломжтой.

- Баримт бичиг . 1-р хэсэг : Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт
<https://must.edu.mn/media/uploads/2025/10/21/mns-5140-1-20211.pdf>
- Баримт бичиг . 2-р хэсэг : Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавих шаардлага
<https://must.edu.mn/media/uploads/2025/10/21/mns-5140-2-202111-2.pdf>
- Баримт бичиг. 3-р хэсэг : Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавих шаардлага.
<https://must.edu.mn/media/uploads/2025/10/21/mns-5140-3-20213.pdf>

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР ДАМЖУУЛЖ САНАЛ ХҮРГҮҮЛЭХ АЛХАМЧИЛСАН ЗААВАР

УИХ-ын гишүүн гэж хэн бэ?

УИХ-ын гишүүн гэдэг нь Монгол Улсын иргэдээс сонгогдож, ард түмнийг төлөөлөн хууль тогтоох үйл ажиллагаа явуулдаг төрийн төлөөлөгч юм. Тэрээр хууль санаачлах, хэлэлцэх, батлахад оролцохын зэрэгцээ Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, улсын төсөв болон бодлогын чухал шийдвэрүүдийг гаргахад оролцдог. Мөн УИХ-ын гишүүн нь иргэдийн санал хүсэлтийг сонсож, тэдний эрх ашгийг төрд төлөөлөн хамгаалах үүрэгтэй. УИХ-ын гишүүдийг иргэд дөрвөн жил тутамд сонгодог бөгөөд гишүүн нь зөвхөн өөрийн тойрог төдийгүй нийт Монгол Улсын иргэдийн эрх ашгийг төлөөлөн ажилладаг.

УИХ-ын гишүүнд санал хүргүүлэх тухай

УИХ-ын гишүүд нь иргэдийн шууд төлөөлөл тул иргэдийн санал, хүсэлтийг сонсож, тэдний эрх ашгийг хамгаалан ажиллах үүрэгтэй. Иймээс иргэд бид өөрсдийгөө төлөөлөн сонгосон УИХ-ын гишүүндээ хандаж, санал бодол, хүсэлтээ тогтмол, идэвхтэй хүргүүлэх эрхтэй бөгөөд энэ нь иргэний оролцооны чухал хэлбэр юм.

Иргэдийн идэвхтэй оролцоо нь төрийн бодлого, шийдвэр илүү бодит, хариуцлагатай байх нөхцөлийг бүрдүүлж, төр засгийн үйл ажиллагааг бэхжүүлэх, илүү сайн засаглалыг бий болгох үндэс болдог. Тиймээс бид төлөөлүүлэн сонгосон гишүүдийнхээ үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, дуу хоолойгоо хүргэж байх нь ардчилсан нийгмийн чухал илэрхийлэл юм.

УИХ-ын гишүүд нь гишүүний чиг үүрэг, бүрэн эрхэд заасны дагуу таны санал хүсэлтийг хүлээн авч хариу өгөх үүрэгтэй байдаг. “Монгол Улсын Их Хурлын Тухай” хуульд заасан УИХ-ын гишүүний бүрэн эрхээс дурдвал¹²:

8.1.1. хууль тогтоомжийн төсөл санаачлах;

8.1.3. санаачилсан хууль тогтоомжийн төслийг өөрийн саналаар татаж авах, хамтран санаачилсан бол нэрээ татаж авах;

8.1.8. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн дагуу асуулт асуух, байр сууриа илэрхийлэх, санал гаргах, санал хураалгах;

8.1.14. хууль тогтоомжийн талаар иргэд, байгууллагаас ирүүлсэн саналыг судлан хариу өгөх, шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн төсөл санаачлах;

8.1.15. иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг судлан хариу өгөх, эсхүл харьяаллын дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжилж энэ тухай хариу мэдэгдэх;

¹² Монгол Улсын Хууль. (2024). Retrieved 2026, from legalinfo.mn: [Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний Боловсролын Үндэсний Зөвлөл. \(n.d.\). Retrieved from nairuulga.mn: https://nairuulga.mn/content/11](https://nairuulga.mn/content/11)

8.1.16.хууль тогтоомжийн биелэлтийн талаар Монгол Улсын Засгийн газар /цаашид "Засгийн газар" гэх/, холбогдох бусад байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл шаардаж авах;

8.1.17.бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хуульд өөрөөр заагаагүй бол аль ч байгууллагад чөлөөтэй нэвтэрч, хэнтэй ч уулзах, шаардлагатай асуудлаар тайлбар, мэдээлэл авах;

8.1.26.сонгогчдод үйл ажиллагаагаа мэдээлэх.

Мөн Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм гэж байдаг бөгөөд үүнийг <https://www.parliament.mn/nn/7438/> дараах холбоосоор орж танилцах боломжтой.

УИХ-ын гишүүнтэй холбогдож санал, хүсэлтээ хэрхэн уламжлах вэ?

Иргэн бүр өөрийг нь төлөөлөн сонгогдсон УИХ-ын гишүүнтэй холбогдож, санал бодол, хүсэлтээ уламжлах эрхтэй. Үүнийг дараах хэд хэдэн хэлбэрээр хэрэгжүүлэх боломжтой.

- **Нэгдүгээрт**, албан бичгээр хандах. Албан бичигтээ асуудлаа товч бөгөөд тодорхой тайлбарлаж, ямар шийдэл хүсэж байгаагаа тодорхой бичих хэрэгтэй. Өөрийн нэр, холбоо барих мэдээллээ заавал оруулж, шаардлагатай бол холбогдох баримт, нотолгоог хавсаргана.
- **Хоёрдугаарт**, цахим шуудан (имэйл)-аар санал хүсэлтээ илгээж болно. УИХ-ын гишүүдийн албан ёсны имэйл хаягийг дээр дурдсан УИХ-ын вэбсайт болон бусад uih.mn гэх мэт нээлттэй эх сурвалжаас авах боломжтой. Имэйл нь богино, ойлгомжтой, ёс зүйг баримталсан байх нь чухал.
- **Гуравдугаарт**, утсаар холбогдох боломжтой. Энэ тохиолдолд асуудлаа урьдчилан бэлтгэж, товч бөгөөд тодорхой танилцуулах нь үр дүнтэй. Утсаар ярьсны дараа албан бичгээр баталгаажуулан хүргүүлэх нь илүү зохистой.
- **Дөрөвдүгээрт**, иргэдтэй хийх уулзалт, нээлттэй хэлэлцүүлэгт оролцох замаар саналаа шууд илэрхийлж болно. УИХ-ын гишүүд тойрогтоо ажиллах үеэрээ иргэдтэй уулзах, санал сонсох уулзалтууд зохион байгуулдаг.
- **Тавдугаарт**, цахим орчин, албан ёсны цахим хуудсаар дамжуулан санал хүргүүлэх боломжтой. Гэхдээ олон нийтийн сүлжээгээр хандахдаа соёлтой, бодит мэдээлэлд тулгуурласан байх нь чухал.

Анхаарах зүйл:

Санал, хүсэлтээ илэрхийлэхдээ зүй боловсон, баримттай, тодорхой байдлаар хандах нь хариу авах, бодитоор шийдэгдэх боломжийг нэмэгдүүлдэг. Түүнчлэн иргэн та УИХ-ын гишүүний бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд санал, хүсэлтээ гаргах нь маш чухал юм. Тухайлбал, "ажилд оруулж өгөөч", "байртай болгоод өгөөч" зэрэг хувь хүний шинжтэй, шууд шийдвэрлэх боломжгүй асуудлаас илүүтэйгээр хууль, бодлого, тогтолцоо, олон нийтийн эрх ашигт хамаарах асуудлыг хөндөж санал хүргүүлэхэд анхаарах хэрэгтэй.

УИХ-ын гишүүний мэдээлэл, үйл ажиллагааг хянах боломж

УИХ-ын гишүүдийн албан ёсны мэдээлэл, холбоо барих хаяг, байршил зэргийг авахыг хүсвэл Монгол Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас болох <https://www.parliament.mn> сайтад хандан үзэх боломжтой.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

ЭХЛЭЛТ УЛСЫН ИХ ХУРЫН ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЫН ГИШҮҮД УЛСЫН ИХ ХУРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЦАХИМ ПАРЛАМЕНТ ТАМГЫН ГАЗАР МЭДЭЭ ТҮНДСЭН ХУҮЛЬ

НҮҮР ХУУДАС ТАНИЛЦУУЛГА ЖУКОВЫН АЛДАРЖАВХЛАН

Танилцуулга

Жуковын
АЛДАРЖАВХЛАН
Монгол Улсын Их Хурлын гишүүн

ТӨГССӨН СУРГУУЛЬ, МЭРГЭЖИЛ

1995 онд	Улаанбаатар хот, арван жилийн 50-р сургууль
1998 онд	Австрали, Сидней, Англи хэлний институт
2000 онд	МБДС, Санхүүч
2005 онд	МУИС-ийн ЭЗДС санхүүгийн магистр

АЖИЛЛАСАН БАЙДАЛ

АЛБАН ТУШААЛААР

- БҮГД
- МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН ДАРГА
- МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН ДЭД ДАРГА
- МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН ГИШҮҮН
- МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Харин УИХ-ын гишүүд ажлаа хэрхэн гүйцэтгэж байгаа, тэдний санаачилсан хууль тогтоомж, ашиг сонирхлын зөрчил, хөрөнгө, орлогын мэдүүлэг, улс төрийн байр суурь, үзэл баримтлал зэрэг илүү цогц, нээлттэй мэдээллийг авахыг хүсвэл <https://www.uih.mn> сайтаар орж танилцах боломжтой.

UNITED info

НҮҮР ГИШҮҮД ИРЦ ХУУЛЬ ТОГТООХ МЭДЭЭ ФАСТЧЕК СУДАЛГААНЫ САН НИЙТИЙН СОНГОЛ НИЙТИЙН ӨРГӨДӨЛ

Жуковийн Алдаржавхлан (Санхүүч)

- Хууль зүйн байнгын хорооны гишүүн
- Эдийн засгийн байнгын хорооны гишүүн

2025 оны хаврын чуулганы ирц

82.5% 10% 7.5% 638

Ирсэн Чөлөөтэй Тасалсан Хоцорсон минут

НАМТАР

ӨГСӨН САНАЛ

ТӨГССӨН СУРГУУЛЬ, МЭРГЭЖИЛ

1995 онд	Улаанбаатар хот, арван жилийн 50-р сургууль
1998 онд	Австрали, Сидней, Англи хэлний институт
2000 онд	МБДС, Санхүүч

АЖЛЫН АЛБАНЫ МЭДЭЭЛЭЛ

Байхгүй

Эдгээр сайтууд нь иргэд УИХ-ын гишүүдийн үйл ажиллагаанд **хяналт тавих, мэдээлэлтэй байх, идэвхтэй оролцох** чухал эх сурвалж болдог.



ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэд үр
дүнтэй оролцох нь

АГУУЛГА

- Иргэд яагаад оролцох ёстой вэ?
- Оролцоог дараагийн шатад гаргах 6 стратеги

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ИРГЭД ЯАГААД ОРОЛЦОХ ЁСТОЙ ВЭ?

Хууль тогтоох үйл ажиллагаа нь зөвхөн УИХ-ын гишүүдийн оролцоогоор явагддаг хаалттай процесс биш. Ардчилсан нийгэмд хууль тогтоох үйл явц нь иргэдийн санал бодол, оролцоог заавал хангасан байх ёстой бөгөөд иргэд өөрсдийн амьдралд шууд нөлөөлөх шийдвэрт дуу хоолойгоо хүргэх бүрэн эрхтэй. Гэвч олон иргэн “би ганцаараа оролцоод нэмэргүй”, “мэдэхгүй учраас оролцож чаддаггүй” гэх мэт шалтгаанаар идэвхгүй үлдэх нь түгээмэл байдаг.

Гарын авлагын энэ бүлэгт иргэдийг хууль тогтоох үйл ажиллагаанд **ганцаар бус, хамтаар, мэдээлэлтэй, судалгаатай, зохион байгуулалттай, стратегитай** оролцох замаар бодит нөлөө үзүүлэхэд чиглэсэн практик зөвлөмжүүдийг орууллаа.

Жишээ:



Нэгэн аймгийн иргэд орон нутгийн байгаль хамгаалалттай бүсэд уул уурхайн тусгай зөвшөөрөл олгосныг хууль батлагдсаны дараа мэдэж, эсэргүүцэл илэрхийлсэн ч шийдвэр аль хэдийн хүчин төгөлдөр болсон байв. Хэрэв тэд төсөл хэлэлцэгдэж байх шатад мэдээлэл авч, хамтран оролцсон бол үр дүн өөр байж болох байлаа.

Ганцаар бус хамтаар оролцох

Нэг иргэний санал бодол үнэтэй ч шийдвэр гаргах түвшинд хүрч, бодлогод нөлөөлөх магадлал харьцангуй бага байж болох юм. Харин ижил асуудлаар санаа зовж буй иргэд нэгдэж, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоо, нутгийн иргэдийн бүлэг, эсвэл олон нийтийн сүлжээ үүсгэн хамтран оролцвол тэдний дуу хоолой илүү тод, илүү хүчтэй болно. Хамтын оролцоо нь тухайн асуудал ганц хүний сонирхол бус, олон нийтийн нийтлэг ашиг сонирхол гэдгийг шийдвэр гаргагчдад ойлгуулах давуу талтай. Мөн иргэд хоорондоо мэдээлэл солилцож, үүрэг хариуцлагаа хуваарилснаар илүү тогтвортой, оролцоог бий болгодог.

Иймээс хууль тогтоох үйл ажиллагаанд оролцохдоо “Би ганцаараа юу хийж чадах вэ?” гэж асуухаас илүүтэй “Энэ асуудлаар надтай адил санаа бодолтой хэн хэн байна вэ?” гэж асуух нь илүү үр дүнтэй байх болно.



Гол санаа



Нэг хүн – ганц дуу хоолой гэж харагдах бол олон хүний дуу хоолой илүү бодлогын шаардлагын түвшинд хүрнэ.

Мэдээлэл, судалгаатай оролцоо

Санал бодлоо илэрхийлэхдээ сэтгэл хөдлөлд суурилсан, хэт эсэргүүцсэн өнгө аястай байх нь анхаарал татаж болох ч бодит шийдвэрт хүргэхэд хангалтгүй байдаг. Харин баримт, судалгаа, бодит жишээнд тулгуурласан санал нь хууль тогтоогчдын хувьд авч үзэх, эргэн харах үндэслэл болдог.

Иргэд хууль тогтоомжийн төсөлд оролцохдоо дараах асуултуудыг өөрсдөөсөө асуух нь зүйтэй. Үүнд:

- Тухайн хууль, шийдвэр хэнд, хэрхэн нөлөөлөх вэ?
- Ямар судалгаа, тоон мэдээлэл үүнийг баталж байна вэ?
- Өөр улс оронд ижил төстэй зохицуулалт хэрхэн хэрэгжсэн бэ?
- Одоо мөрдөж буй зохицуулалтын сул тал нь юу вэ?

Эдгээр асуултад хариулсан, нотолгоотой санал нь шийдвэр гаргагчдын хувьд илүү үнэмшилтэй, бодлогын түвшинд авч үзэх боломжтой болдог. Харин буруу эсвэл дутуу мэдээлэлд суурилсан оролцоо нь иргэдийн итгэлийг алдагдуулж, оролцооны үр нөлөөг бууруулдаг. Иймээс хууль тогтоомж, шийдвэрийн талаарх албан ёсны эх сурвалжийг ашиглах, төслийн бодит эхийг уншиж танилцах нь зайлшгүй шаардлагатай.

Иргэд мэдээллийг нэг эх сурвалжаас авах бус, олон эх сурвалжийг харьцуулж шалгах, цуурхал, таамаглалд автахгүй байх соёлд суралцах нь хамгийн чухал юм.

Жишээ:



Нийгмийн халамжийн тухай хуулийн төсөлд өөрчлөлт оруулах үед хэсэг иргэд “иргэд хохирно” гэж эсэргүүцсэн ч тодорхой санал дэвшүүлээгүй. Харин өөр нэг бүлэг иргэд ижил асуудлаар судалгаа хийж, ямар бүлэгт ямар сөрөг нөлөө үзүүлэхийг тооцоолон, өөр хувилбар санал болгосноор хуулийн төслийн зарим эрсдэлтэй заалт өөрчлөгдсөн.

НОТОЛГООНД СУУРИЛСАН ОРОЛЦОО - ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ

Нөлөөллийн ба кампанит ажил

Нэг удаагийн эсэргүүцэл, богино хугацааны шүүмжлэл нь үр дүн багатай байхаас гадна ихэвчлэн удаан үргэлжилдэггүй. Харин тодорхой зорилго, төлөвлөгөөтэй нөлөөллийн болон кампанит ажил нь бодит өөрчлөлт авчрах боломжтой.

Үр дүнтэй кампанит ажил нь юуг өөрчлөх, аль заалтад нөлөөлөх, хэний шийдвэрт чиглэж байгаагаа тодорхойлсон байдаг. Үүнд гарын үсэг цуглуулах, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, албан бичиг хүргүүлэх, бодлогын санал боловсруулах зэрэг арга хэлбэрүүд багтана.

Иргэдийн оролцоо нь богино хугацааны эсэргүүцлээр хязгаарлагдах бус, үе шаттай, зорилготой нөлөөллийн үйл ажиллагаа байх нь илүү үр дүнтэй.

Жишээ:



Хотын ногоон байгууламж багасаж буйтай холбоотойгоор иргэд эхлээд мэдээлэл түгээж, дараа нь гарын үсэг цуглуулж, эцэст нь нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан. Үүний үр дүнд хотын хөгжлийн төлөвлөгөөнд ногоон бүсийн хамгаалалтын заалт нэмэгдсэн.

ЗОРИЛГОТой КАМПАНИТ АЖИЛ – БОДИТ ӨӨРЧЛӨЛТ

Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээг зөв ашиглах

Хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээ нь иргэдийн санал бодлыг олон нийтэд хүргэх, дэмжлэг авах чухал хэрэгсэл юм. Гэвч энд хувь хүнийг дайрах, буруутгах бус, бодлогын асуудалд төвлөрсөн, ойлгомжтой, баримтад суурилсан мэдээлэл түгээх нь чухал.

Олон нийтэд хүргэх мессеж нь энгийн, нэг утгатай, бодит асуудлыг хөндсөн байх ёстой. Хэвлэл мэдээлэлд хандахдаа тухайн асуудлын нийгэмд үзүүлэх нөлөө, яагаад олон нийтийн анхааралд байх ёстойг тодорхой тайлбарлах нь үр дүнтэй.

Нийгмийн сүлжээ нь зөвхөн эсэргүүцэх талбар бус, дэмжигчдийг татах, хамтран оролцох, хүмүүсийг холбох хэрэгсэл гэдгийг ухамсарлах нь зүйтэй.

Жишээ:



Нэгэн хуульд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор иргэд бодлогын асуудлыг тайлбарласан товч бичлэг, инфографик бэлтгэн олон нийтэд түгээснээр хэвлэл мэдээллийн анхаарал татаж, УИХ-ын гишүүд тайлбар өгөхөд хүрсэн.

ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГ - НӨЛӨӨЛЛИЙН ХҮЧ

Зөв цагтаа, албан сувгаар оролцох

Иргэдийн оролцоо ихэвчлэн хууль батлагдсаны дараа идэвхэждэг нь түгээмэл. Гэвч бодит нөлөө үзүүлэх хамгийн боломжит үе нь хууль санаачлагдах, хэлэлцүүлэг явагдаж байх шат юм. Иймээс иргэд шийдвэр гаргах процессын үе шатыг ойлгож, аль үед оролцвол илүү үр дүнтэйг мэдэх нь чухал.

Жишээ:



Иргэд хууль батлагдсаны дараа гомдол гаргасан ч үр дүн гараагүй. Харин дараагийн удаа ижил төрлийн төсөл олон нийтийн хэлэлцүүлэгт орж байх үед албан санал өгснөөр төсөлд өөрчлөлт орсон.

Батлагдсаны дараа эсэргүүцэх бус, батлагдахаас өмнө оролцох

Албан ёсны оролцооны сувгуудыг ашиглах. Иргэд хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох албан ёсны олон суваг бий. Үүнд нийтийн сонсгол, хэлэлцүүлэг, албан санал, өргөдөл, УИХ-ын гишүүдтэй уулзах зэрэг хэлбэрүүд орно. Эдгээр сувгийг ашигласан оролцоо нь иргэдийн саналыг албан ёсоор бүртгэгдэж, баримтжих боломжийг бүрдүүлдэг.

Үр дүнтэй оролцоо нь зөвхөн идэвхтэй байхаас гадна соёлтой, хариуцлагатай байхыг шаарддаг. Хувь хүнийг бус бодлогыг шүүмжлэх, доромжлол, сүрдүүлэг ашиглахгүй байх, худал мэдээлэл түгээхээс зайлсхийх нь иргэдийн оролцооны чанарыг тодорхойлдог.

Жишээ:



Нэгэн асуудлаар иргэд доромжлол, сүрдүүлэг ашигласан нь анхаарал татсан ч дэмжлэг алдахад хүргэсэн. Харин бодлогын үндэслэлтэй, тайван хэлбэрээр санал гаргасан бүлэг нь олон нийтийн дэмжлэгийг авч чадсан.

ДҮГНЭЛТ

Хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нь ардчиллын салшгүй хэсэг юм. Гэхдээ энэ оролцоо нь ганцаарчилсан, эмх замбараагүй бус, хамтын, мэдээлэлтэй, зохион байгуулалттай, соёлтой байх үедээ бодит өөрчлөлт авчирдаг. Энэхүү гарын авлага нь иргэдийг илүү үр дүнтэй оролцоонд уриалж, өөрсдийн дуу хоолойг бодлогын түвшинд хүргэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой болно.

ОРОЛЦООГ ДАРААГИЙН ШАТАД ГАРГАХ

6 СТРАТЕГИ

1. Дотоод дэмжигчийг олж, хамтрах

Хууль тогтоох үйл явц нь зөвхөн олон нийтийн дарамтаар биш, парламентын дотоод механизмаар урагшилдаг. Иймээс тухайн асуудлыг ойлгож, дэмжих магадлалтай УИХ-ын гишүүн, ажлын хэсгийн гишүүн, салбарын мэргэжилтэнийг олж, хамтран ажиллах нь оролцооны нөлөөг эрс нэмэгдүүлдэг.

Зөвлөмж: Шийдвэр гаргагч бүр эсрэг тал биш. Ижил байр суурьтай шийдвэр гаргагчид хэн хэн байгааг судлах, таныг хэрхэн дэмжиж болохыг тооцоолох.

2. Шаардлагаас гадна шийдэл санал болгох

Асуудлыг олж харж шүүмжлэлт дуу хоолой илэрхийлэхийн зэрэгцээ тухайн асуудлыг хэрхэн шийдэж болох талаар шийдэл санал болгосноор эерэг өөрчлөлтийг бий болгоно. Иргэдийн оролцоо шаардлагаар хязгаарлагдах бус, өөр хувилбар, бодлогын санал дэвшүүлсэн үед илүү үр дүнтэй болдог. Зарим тохиолдолд иргэд өөрсдөө хуулийн заалтын шинэчилсэн найруулгыг санал болгох ч боломжтой.

Зөвлөмж: Асуудлыг нэрлээд зогсохгүй, шийдлийг зураглаж үзэх.

3. Мэргэжлийн дуу хоолойг нэгтгэх

Иргэдийн санал бодол судалгаа, баримтты нэгдсэнээр илүү хүчтэй үндэслэлтэй болно. Тиймээс судлаачид, салбарын мэргэжилтэн, хуульчдын оролцоо нь иргэдийн санааг илүү гүнзгийрүүлж бодлогын үндэслэл болгоход тусална.

Зөвлөмж: Мэргэжилтэн, судлаачдын байр суурь таны байр суурийг улам хүчтэй болгох боломжтой тул сайн судлагаатай байх нь чухал.

4. Албан хүсэлт, албан бичиг зэрэг нь таны оролцоог баталгаажуулна.

Олон нийтийн сүлжээнд таны бичсэн пост сэтгэгдэл нь албан ёсны санал гэж тооцогдох боломжгүй юм. Харин албан бичгээр өгсөн санал үлддэг. Иргэдийн оролцоо албан ёсны хэлбэрээр бүртгэгдэж, баримтажсан тохиолдолд дараа нь хяналт тавих, эргэж нэхэх боломж бүрддэг.

Зөвлөмж: Таны санал, байр суурь ямагт баримт болж үздэх учиртай.

5. Хэрэгжилтэд хяналт тавих

Хууль батлагдсанаар оролцоо дуусахгүй. Жинхэнэ нөлөө нь хэрэгжилтийн шатад илэрдэг. Иргэд журам, дэд зохицуулалт, хэрэгжилтийн тайланг хянаж, олон нийтэд мэдээлснээр бодит өөрчлөлтийг баталгаажуулж чадна.

Зөвлөмж: Баталсан хуулийг "яаж хэрэгжүүлж байна вэ?" гэдэгт үргэлж анхаарал хандуулах.

6. Хамтын оролцоогоор эрсдэлийг бууруулах

Иргэдийн оролцооны үед үүсч болох төрөл бүрийн эрсдлүүд байдаг. Харин хамтаар, байгууллагаар, сүлжээгээр оролцох нь иргэдийг хамгаалж, ганцаардуулахгүй байх бодит хамгаалалт болно.

Зөвлөмж: Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэхдээ ямагт зөв зохион байгууллалттай, эрсдэлгүй хэлбэрийг сонгоорой.



Энэ хүн бол Батаа. Тэрээр өөрийн амьдардаг суманд хүнсний ногоо тариалан ажиллаж амьдардаг. Түүний газар тариалангийн бүтээгдэхүүнээс олсон орлого нь өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр болдог.




УИХ импортоор орж
ирэх хүнсний ногооны
татварыг бууруулна



Батаа уг мэдээллийг хараад их
бужимдаж, олон нийтийн сүлжээнд live
хийсэн боловч төдийлөн үр дүн
олсонгүй. Ийнхүү тэрээр хууль
санаачлагчдад өргөдөл бичихээр болов.







Ийнхүү Батаа болон олон мянган хүнсний ногоо тариалагчид өөрсдийн эрх ашгийг олон нийт, ИНБ, хэвлэл мэдээллийн дэмжлэгтэйгээр өөрсдийн хүчээр хамгаалж чадсан юм.